

ГОВЬ-АЛТАЙ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Говь-Алтай аймаг 2010 онд зохион байгуулж, хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн дараахь ажил арга хэмжээнүүдийг онцлох үйл явдлууд хэмээн нэрлэж байна.

1.АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 70 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭВ.




Их Монгол Улс байгуулагдсаны 804 жил, Ардын хувьсгалын 89 жил, Говь-Алтай аймаг байгуулагдсаны 70 жилийн ой, хурдан морины баруун бүсийн зуны уралдаан, аймгийн баяр наадмыг 2010 оны 7сарын 27-29-ны өдрүүдэд зохион байгуулж, Алтайчууд их ојаоо хөдөлмөр бүтээлийн өндөр амжилтаар угтлаа.




Аймгийн 70 жилийн ойгоор бүх сумууд “МИНИЙ НУТАГ САЙХАН” орон нутгаа сурталчлах спорт урлагийн наадмыг амжилттай зохион байгууллаа.

2. АЙМАГ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГОО ӨӨРӨӨ БҮРДҮҮЛДЭГ БОЛЛОО.



Аймаг орон нутгийн төсвийн орлогоо 108.2 хувиар биелүүлж, зарлагад эзлэх орлогын хувь 90.5-д хүрч зорилтот түвшингээс 22.3 функтээр давсан байна.

2010 он манай аймгийн тухайд орон нутгийн төсвийн нийт зарлагын 93.4 хувийг орлогоороо санхүүжүүлэх, Говь- Алтай аймаг байгуулагдсаны 70 жилийн ой тохиосон зэрэг ихээхэн хөрөнгө мөнгө шаардсан онцлог жил байлаа



3. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА .



Аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн хүрээнд Улаанбаатар хотод тус аймгийн гаралтай болон тус аймагт үйл ажиллагаа явуулдаг 62 бизнес эрхлэгчдийг хамруулан “Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-ыг Чингис цогцолборт, “Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн болон брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа”-г МИШЭЭЛ ЭКСПО төвд 68 үйлдвэрлэгчийг тус тус хамруулан амжилттай зохион байгууллаа.

4. АЛТАЙЧУУД УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВТЭЙ БОЛЛОО.



“Уран охид” ХХК Уламжлалт анагаах ухааны төвийн барилгыг улсын төсвийн хөрөнгө 499.2 сая төгрөгөөр барьж ашиглалтанд оруулан, эмнэлэгийн нээлтийн үйл ажиллагааг 2010 оны 11 сарын 30-нд хийж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж иргэдийн талархал хүлээж байна.

5. АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС УЛСДАА ТЭРГҮҮЛЛЭЭ.



Аймгийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс нь 2010 онд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар дэвшүүлсэн зорилт болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдсан, үр ашигтай хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний суурь сүлжээг бий болгон үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж амжилттай ажилласнаар аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 3,4% болж өмнөх оноос 0,5 пунктээр буурсан ба нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаагаар ядуурлын түвшин буурсан зэрэг үзүүлэлттэйгээр улсын хэмжээнд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын хэлтсүүдээс ажлаараа шалгарч, 1-р байранд орж “Өргөмжөл”, мөнгөн шагналаар шагнагдлаа.

6. АЙМГИЙН ТӨВ ЗАМАА ШИНЭЧИЛЛЭЭ



Улсын төсвийн хөрөнгөөр Алтай хотын төвийн 6,7 км хатуу хучилттай авто замыг шинэчлэн сэргээн засварлах ажлыг зам засвар, арчлалтын “Заабар” , “ Говь-Алтай АЗЗА” компаниуд хариуцан үйцэтгэж , 2010 оны 10 –р сард ашиглалтанд хүлээлгэн өглөө.

“Алтай хүдэр” компанийн 2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Таян нуурын уурхай , Бургастайн боомт чиглэлд 168 км сайжруулсан зам барьж, үүнээс Алаг нуурын говьд 40 км зам шинээр тавиад байна.

7. БАРУУН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ СИСТЕМД ЗАРИМ СУМДУУД ХОЛБОГДЛОО



Сум, суурин газрын цахилгаан эрчим хүчний хангамжийн эх үүсвэр			
Д/д	Сум, тосгоны нэр	Цахилгаан эрчим хүчний Эх үүсвэр	Хүчдэл (кВт)
1	Алтай	Нарны Цахилгаан станц /кВт/	200
2	Бугат		140
3	Баянтоорой		100
4	Баян-Уул		15
5	Бигэр		35
6	Гуулин		35
7	Дэлгэр		10
8	Дарви		35
9	Жаргалан		35
10	Тайшир		35
11	Тонхил		10
12	Төгрөг		15
13	Халиун		15
14	Хөхморьт		15
15	Цогт		35
16	Чандмань		35
17	Шарга		35
18	Эрдэнэ		10
19	Есөнбулаг		35
20	Цээл	Нар, салхи хосолсон цахилгаан станц /кВт/	150

Алтай хотын цахилгаан хангамжийг баруун бүсийн эрчим хүчний систем, Тайширын усан цахилгаан станцуудаас тодорхой дэмжлэг авч, Есөнбулаг эрчим хүч ХХК 10 дизель станц ажиллуулан цахилгаан үчээр нийм тасралтгүй хангаж байна.

Сумдын хувьд: Есөнбулаг эрчим хүч ХХК-с Халиун, баруун бүсийн цахилгаан эрчим

хүчний системээс Дарив, Хөхморьт, Тонхил, Төгрөг, Шарга сумууд, Тайширын УЦС-аас Жаргалан, Тайшир, Баян-Уул сумууд байнгын цахилгаан эрчимүүжээр хангагдаж, Алтай, Бугат, Цээл сум, Баянтоорой баг нар, нар салхины цахилгаан станцыг дизель станцтай хослуулан цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

8. АЙМАГ ТӨМРИЙН ХҮДРЭЭ ЭКСПОРТОЛЖ ЭХЭЛЛЭЭ.



Цээл сумын Таяннуурын төмрийн хүдрийн ордод үйл ажиллагаа явуулж буй “Алтайн хүдэр” ХХК нь тайлант онд 30021.4 тонн хүдрийг экспортод гаргаад байна. 2010 онд Мандал-Хүдэр, Говь-Гоулд зэрэг нүүрсний уурхайгаас 28800 тонн нүүрс олборлоод байна

9. АЛТАЙ ХОТ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНТЭЙ БОЛЛОО.



Аймгийн 70 жилийн ойн ажлын хүрээнд хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг “Шадар туслагч- ХХК 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хийж ашиглалтанд орууллаа.

10. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА АЯН ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



Хүүхэдтэй ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, харилцаа холбоог сайжруулах, тогтмолжуулахуухэд эцэг эх багш н арыг хүүхэдтэй холбоотой мэдээ мэдээллээр хангах, эцэгүүдийн зөвлөлийг идэвхжүүлэх, хүүхдийн эрхийн зөрчлийг судлах, арилгах. “Хүүхдийн төлөө хамтдаа” аяныг зохион байгууллаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР.